1.6.5 Уурхайн бусад объектууд

Тус далд уурхайн тэсрэх материалын агуулахыг уурхайгаас хойд зүгт 0.45 км зайд барьж байгуулна. Тэсрэх бодисын агуулах нь 20 тонны багтаамжтай 1 ширхэг контейнер, тэсэлгээний хэрэгслийн агуулах нь 20 тонны багтаамжтай 1 ширхэг контейнер, тэсрэх материал бэлтгэх зориулалттай 10 тн-ын контейнер тус тус байна. Тэсрэх материалын агуулахыг зэвсэглэсэн гэрээт харуул хамгаалалтын ажилтнууд хамгаална.

Сэлбэг материалын агуулахыг 40 тн багтаамжтай контейнерт байршуулах бөгөөд зарим овор ихтэй тоног төхөөрөмж, машин механизмын сэлбэгийг зориулалтын талбайд саравчид хадгална.

Нэвтрэх байр: Нэвтрэх байр нь аюулгүйн төв цэг юм. Энэ байр нь нэг давхар, төмөр каркастай, сэндвич ханатай, дулаалгатай тааз, гипсэн доторлогоотой, нийт 20 м² талбай бүхий байшин байна. Энэ байранд харуул хамгаалалтын хэсэг, аюулгүй ажиллагааны сургалтын алба, хяналтын хэсгүүд байрлана. Шинээр ирсэн зочид болон бүх ажилчид тус байраар орж шалгуулан, анхан шатны сургалтад хамрагдсаны дараа нэвтэрнэ.

Уурхайн шалган нэвтрүүлэх байр нь төслийн талбайд орж гарч байгаа үндсэн болон гэрээт ажиллагсад болон зочдод хяналт тавих, үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн байна. Уурхайн талбай нь зөвхөн нэгцэгээр нэвтрэх боломжтой байна. Шалган нэвтрүүлэх пост нь үйлдвэрийн дотоод журам, харуул хамгаалалтын эрх зүйн актын дагуу ажиллаж төслийн талбайд хэв журам сахиулах, хууль эрх зүйн аливаа зөрчлийг илрүүлж, зөрчил гаргагчдыг саатуулан шалгах зориулалттай.

Шалган нэвтрүүлэх пост нь дараах зүйлсээр тоноглогдсон. Энд:

- Харилцаа холбооны богино долгионы радио станц
- Камерын хяналтын дэлгэц, удирдлагын хэсэг
- Зочдод хөдөлмөрийн аюулгүй байдлын хэрэгсэл өгөх хэсэг
- Ирсэн болон гарж буй иргэнд үзлэг хийх хэсэг
- Тээврийн хэрэгсэл, иргэнийг түр саатуулах байр
- Гэрэлтүүлгийн ба цахилгаан хангамжийн эх үүсвэр, анхааруулах, хориглох, сануулах, заах дохио, тэмдгүүд
- Харуулын ажилчдын түр амрах өрөө



Зураг 30. Нэвтрэх байрны байгуулалт

Далд уурхайн дохиолол холбоо: Уурхайн дор дурдсан цэгүүдэд богино долгионы станц тавигдсан байхаар тусгалаа. Энд:

1. Гол амны эхлэл ба төгсгөлд /2 ш/
2. Далд уурхайн зэрэг ашиглагдах түвшин бүрд /2 ш/
3. Баяжуулах үйлдвэрт 3 ширхэг, уурхайн даргын өрөөнд 1 ширхэг, нөөцөд 1 ширхэг нийт 9 ширхэг тавина. Богино долгионы холбооны хэрэгслийн тоо бүртгэл, техникийн бэлэн байдлыг диспетчер буюу цахилгааны инженер хангаж ажиллана.

1.6.6 Гадаад тээвэр

Баяжуулах үйлдвэрээс гарах гянтболдын баяжмалыг авто машин болон төмөр замаар тээвэрлэн БНХАУ-д экспортлохоор төсөлд тусгасан.

Авто тээвэр: Уурхайгаас Улаанхус сумаар дамжин Баян-Өлгий аймгийн төв Өлгий хот хүртэл 140 км орон нутгийн чанартай шороон замаар, Өлгий хотоос Улаанбаатар хот хүртэл 1,684 км хатуу хучилттай засмал замаар тээвэрлэнэ.


Төмөр замын тээвэр: Улаанбаатар хотоос улсын урд хил хүртэл 714 км төмөр замаар тээвэрлэнэ.

Хүснэгт 65. Тээвэрлэх баяжмалын хэмжээ

№	Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Ашиглалтын жил				Нийт
			1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	
1	Гянтболдын баяжмал	тн	51.8	205.7	270.8	214.7	743.0

1.6.7 Газар ашиглалт

Тухайн төсөл хэрэгжсэнээр ашиглалтын 4 жилийн хугацаанд нийт талбайн 3.28 хувь нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр эвдрэлд өртөхөөр байна.




Зураг 31. Гадаад тээврийн маршрут

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн талбайн байгаль орчны төлөв байдал

Төслийн талбай нь Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос баруун зүгт 1800 км, Өлгий хотоос баруун тийш 130 км, Цагаан нуурын дамжлага баазаас 90 км, Улаанхус сумын төвөөс 70 км зайд тус тус байрлана.




Зураг 32. Засаг захиргааны зураг

Газрын гадаргуу:


Баруун талаараа Алтайн нурууны хяр дагаж БНХАУ-ын Шинжаан-Уйгарын Өөртөө засах оронтой 150 км, хойд талаараа Сийлхэмийн нуруу дагаж ОХУ-ын Алтайн Бүгд Найрамдах Улстай 225км, зүүн талаараа Увс аймагтай 165 км, зүүн ба урд талаараа Ховд аймагтай 450 км нутгаар хиллэдэг. Далайн түвшнээс дээш 1301-4374 метрт оршино, нутаг дэвсгэрийн 95,3% нь 1600 метрээс дээш өндөрт байна. Аймгийн нутаг дэвсгэр кайнозойн эриний дөрөвдөгч галвын үеийн гол, мөрөн, нуур, усны ажлагаагаар тогтсон элс, шавар, хайрга голлосон тунамалтай, уулын хүрэн ба цайвар хүрэн хөрс зонхилсон гол, мөрний саваар нугат намгийн заримдаг давсархаг хөрс, өндөр уулын бүсэд хад асга бүхий уулын тундрийн ба уулын нугын хөрстэй, элэгдэл, өгөршлийн ажиллагаагаар тогтсон хонхор, гүдгэр, уул нуруудаас тогтдог. Геологи-тектоникийн мужлалын хувьд Монгол Алтайн атираат мужийн баруун ба баруун хойт хэсэгт оршдог юм. Даян, Хотон, Хоргын цэнгэг устай том, жижиг 80-аад нуур, 100 гаруй гол, горхи, 200 гаруй булаг, шандтай. Толбо, Ачит нуур нь загасны агнуурын нөөцтэй. Ховд, Цагаан, Согоог, Ёлт, Сагсай, Булган, Ганц мод, Бөхмөрөн зэрэг томоохон голтой, Ховд гол 506 км үргэлжилдэг.

Ландшафт: Нутгийн хойд хэсгээр уулын нуга, өндөр уулын хурай хээрийн бага хэрчигдэлтэй ландшафт, уулсын доод биеэр Алтайн хуурай хээрийн бага хэрчигдэлтэй элэгдэл-эвдрэлийн ландшафт тархсан бол баруун хойд, баруун өмнөд хэсэгт өндөр уулын нугын тундрийн ландшафт тархсан байна. Харийн нутгийн зүүн хэсэгт өмнөдийн хуурай хээрийн ландшафт уулс хоорондын хөндий хотгоруудаар цөлийн ландшафт зонхилсон байна. Мөн дундаж өндөр уулсын хажууг дагаж ботуульд, ботууль-жижиг дэгнүүлт үетэн, алаг өвст хээртэй, биелэг өвс, ботууль, ерхөг, дааган сүүл зонхилж, шивээт хялгана, агь бүхий хээр ч тохиолдоно.

Төслийн талбай район далайн түвшнээс дээш 2548.0-2815.3 метрийн үнэмлэхүй өндөрт байрлаж, газрын гадаргын налуу буюу хэвгий 6.6-86.0⁰ (градуст) байна



Зураг 33. Төслийн талбайн районы д.т.д үнэмлэхүй өндөршлийн зураг



Зураг 34. Төслийн талбайн районы газрын гадаргын хэвгий буюу налуу (градус)


Баян-Өлгий аймгийн уур амьсгалын горим:

Баян-Өлгий аймгийн нутаг нь далайн түвшнээс дээш 1350-4374 метр өргөгдсөн, өндөр уулсаар хүрээлэгдсэн учир эх газрын эрс тэс уур амьсгалтай юм. Манай аймгийн нутаг дэвсгэр нь Монгол Алтайн нурууны бүсэд байдаг мөнх цастай, өндөр уул хадтай, шовх сарьдаг, гол мөрний сав газар ихтэй.

Манай уулсын хамгийн өндөр уул Таван богд 4374 м, Цамбагарав 4108 м, Цэнгэл хайрхан 3978 м зэрэг оргилууд оршдог. Монгол Алтайн нууруудын хооронд хотгорууд олон байдаг. Тэдгээрийн томхон нь Даян, Толбо нуурын хотгор юм. Баян-Өлгий аймгийн нутгаар агаарын жилийн дундаж температур сүүлийн /1964-2004 он/ 40 жилд 0,6 градусаар дулаарснаас дулааны улиралд 0.28 градусаар, хүйтний улиралд 0.55 градусаар дулаарсан. Уур амьсгалын мужлалын хувьд чийглэг, сэрүүн нэн хүйтэн, хуурайдуу, сэрүүвтэр хүйтэн, нэн хүйтэн бүсүүдэд оршдог.

Уур амьсгалын мужлалын хувьд хуурай, дулаавтар, хуурайдуу, сэрүүвтэр, чийглэг, нэн сэрүүн бүсүүдэд оршдог

Монгол оронд агаарын жилийн дундаж температур, нийлбэр хур тунадасны газарзүйн хуваарилалт нутаг дэвсгэрийн янз бүрийн хэсэгт харилцан адилгүй. Зураг 6-д Цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан Монгол орны жилийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны нормын (1991-2020 оны) тархалтын мэдээллийг Төв аймгийн хэмжээнд таслан үзүүлэв.



Зураг 35. Агаарын жилийн дундаж температур, жилийн нийлбэр хур тунадас (Эх сурвалж: www.irimhe.natstat.gov.mn/)

Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд олон жилийн дундаж агаарын температур нутгийн ихэнх хэсгээр -8...0 °C, зүүн хэсгээр 0...+2°C байдаг. Харин жилийн нийлбэр хур тунадас 100...200 мм унадаг байна.

Баян-Өлгий аймгийн уур амьсгалын ерөнхий хандлагыг “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан”-гийн 2005-2021 оны буюу 17 жилийн мэдээг ашиглан боловсруулав.



Зураг 36. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн хандлага

2005-2021 оны олон жилийн явцаас харахад жилийн агаарын дундаж температур ойролцоогоор 0.74°C -аар дулаарсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор сүүлийн жилүүдийн (2012 оноос) ерөнхий хандлага нэмэгдсэн нь Зураг 5-д харагдаж байна. Энэ хугацаанд хамгийн хүйтэн жил 2005 онд -0.3°C байсан бол хамгийн дулаан жил 2017 онд $+2.7^{\circ}\text{C}$ хүрч байжээ. Харин хур тунадасны олон жилийн өөрчлөлтөөс үзвэл өссөн хандлагатай бөгөөд жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ 82.6...175.2 мм-ийн хооронд хэлбэлзсэн байна.


Улаанхус сумын уур амьсгалын горим: Улаанхус сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлтийг Монгол улсын “Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн” Дэлхийн цаг уурын байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу Улаанхус цаг уурын харуулын (ДТД-1775м) 1991-2020 оны агаарын температур, хур тунадасны стандарт нормыг цаг хугацааны сарын алхамтай тооцоолсон мэдээг ашиглав.

Хүснэгт 66. Улаанхус сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлт

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Сарын дундаж агаарын температурын үзүүлэлтүүд													
Дундаж	-21.9	-15.5	-6.3	3.0	9.3	15.2	16.8	15.0	8.5	0.3	-10.2	-18.5	-0.4
Үнэмлэх их температур	0	5.4	18.5	26.6	28	33.1	34.7	32.1	28.6	20	14.1	4.2	34.7
Үнэмлэх бага температур	-44	-42.5	-32.8	-22.5	-10	-3.8	0	-1.6	-11	-18.4	-35.1	-44.5	-44.5
Сарын нийлбэр хур тунадасны үзүүлэлтүүд													
Нийлбэр	0.7	0.6	1.8	3.5	11.1	24.7	29.9	21.4	5.6	1.3	1.3	1.4	103.3
Хамгийн их	4.4	5.2	13.7	19.5	52.7	75.9	75.5	69.4	18.8	7.8	4.5	10.7	75.9

Энэхүү мэдээлэл нь цаг уурын байгууллагаас гарч байгаа мэдээ мэдээллийн ерөнхий суурь нөхцөл болохоос гадна газар тариалан, харилцаа холбоо, барилга байгууламж, авто зам, ачаа тээвэр, эрчим хүч, хот төлөвлөлт зэрэг олон салбаруудын техникийн баримт бичгийн стандарт норм, дүрэм болж ашиглагдах зориулалттай.


Бид энэхүү судалгаандаа Улаанхус сумын уур амьсгалыг тодорхойлохдоо “Цаг уур, орчны шинжилгээний газар, Байгаль орчин, ус цаг уурын мэдээллийн төв архив”-аас Улаанхус харуулын сүүлийн 10 жилийн (2012-2021 он) агаарын температур, хур тунадас болон салхины мэдээ, материалыг авч ашиглав.



Зураг 37. Улаанхус сумын уур амьсгалын горим


Улаанхус сумын нутагт 2012-2021 оны хооронд дунджаар агаарын температур -1.2...+1.2°C-ын хооронд хэлбэлзсэн бөгөөд өвлийн улиралд -25.7...-9.8°C, хаврын улиралд -9.9...+12.2°C, зуны улиралд +13.3...+18.4°C харин намрын улиралд -11.8...+10.8°C хүрсэн байна. Тухайн бүс нутагт жилд орох хур тунадасны нийлбэр 89.9...196.5 мм-ийн хооронд хэлбэлзэх бөгөөд өвлийн улиралд 0.7...1.3 мм, хаврын улиралд 3.5...12.6 мм, зуны улиралд 31.2...41.5 мм, намрын улиралд 1.2...6.8 мм-ийн хооронд хэлбэлздэг. Хамгийн их хур тунадас 7 сард дунджаар 41.5 мм, хамгийн бага хур тунадас 1 сард дунджаар 0.7 мм орчим ордог байна.

Гадаргын онцлог, агаарын массын улирлын шилжилт циклон ба эсрэг циклоны солигдох байдал зэргээс үүдэн Монгол оронд салхи ихтэй байдаг. Салхины горимын үндсэн үзүүлэлт болох салхины чиглэл ба хурд нутаг бүрд харилцан адилгүй байдаг.



Зураг 38. Улаанхус сумын салхины хурд

Судалгаанд хамрагдаж буй нутагт салхины хурд жилд дунджаар 1.0 м/с байсан бөгөөд хавар, намрын улиралд өсөж өвөл, зуны улиралд буурсан байна. Салхины хурдны хамгийн их утга нь 5 сард дунджаар 1.8 м/с, хамгийн бага утга нь 1 сард 0.4 м/с ажиглагдсан. Салхины зүг чиглэлийн давтагдал нь тухайн орон нутгийн физик газарзүйн тогтолцооны нөлөөлөлтэй. Салхины зонхилох зүг чиглэлийн давтагдлыг хувиар илэрхийлэн 4 улирлаар (Өвөл, хавар, зун, намар) 8-р зураг.



Зураг 39. Улаанхус сумын салхины зүг, чиглэлийн давтагдал

Зургаас харахад Улаанхус сумын нутагт өвлийн улиралд баруун зүгийн салхи зонхилон ажиглагддаг бол хавар, зун, намрын улирлуудад баруун хойд зүгийн салхи зонхилдог байна.

Хөрсөн бүрхэвч: Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн төслийн талбайд нугат-намгийн цэвдэгт хөрс, уулын нугат хээрийн хөрс, уулын хөрс, өндөр уулын хээрийн хөрс тус тус тархсан байна.

Ургамлын нөмрөг: Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт байрлах төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Ховдын уулын хээрийн тойрогт хамаардаг (Өлзийхутаг Н.).

Ургамлын хээрийн судалгааг 2026 оны 4 сард хийсэн бөгөөд экологи, ургамлан бүлгэмдлийн бүтэц бүрэлдэхүүн онцлогоос харгалзан хэмжилт судалгааг явуулсан.

Уг судалгаагаар төслийн талбайн болон түүний ойр орчмын өндөр уулын хээрээс цөлийн хээр хүртэлх ургамлан бүлгэмдлийг дагаж 16 овогт хамаарах 31 төрлийн 45 зүйл ургамлыг бүртгэгдсэн. Төрөл зүйлийн тоо бүрхэц, нягтшил нь тухайн жилийн цаг агаарын онцлогоос ихээхэн хамааралтай байдаг учир тухайн жилийн онцлог хээрийн судалгааны цаг үеэс хамаарч ургамлын төрөл зүйлийн тоо бага зэрэг өөрчлөгдөж болно.

Ан амьтан: Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт орших тус газар нь Монгол орны амьтны газар зүйн мужлалаар Баруун хойд Монголын тойрогт хамаарна (Банников, 1954).

Хөхтөн: Тухайн бүс нутагт тархсан хөхтөн амьтад, тэдгээрийн хамгаалагдсан байдлыг харуулав. Энд нутагт тархсан хөхтөн амьтдаас Монгол улсын “Амьтны тухай хууль”-д цоохор ирвэс, Ховор амьтны жагсаалтад аргаль, янгир, хадны суусар, Монгол

улсын улаан номд (2014) аргаль, янгир, цоохор ирвэс, хадны суусар зэрэг оржээ. Зэрлэг амьтан ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн I хавсралтад цоохор ирвэс, II хавсралтад аргаль, мануул, шилүүс, саарал чоно тус тус орсон. Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцын I хавсралтад цоохор ирвэс, II хавсралтад аргаль орсон. Монгол улсын хөхтөн амьтны Улаан дансанд "Устаж болзошгүй" ангиллаар аргаль хонь, цоохор ирвэс, “Ховордож болзошгүй” ангиллаар саарал чоно, шар үнэг, хярс үнэг, мануул, шилүүс, янгир оржээ.

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа Баян-Өлгий аймгийн Улаанхус сум нутагт анх Шеруши хошуун 1923 онд байгуулагдаж 1938 онд Улаанхус сум болж өөрчлөн байгуулагдсан. Монгол Улсын баруун хойд хэсэгт баруунаас зүүн тийш шулуунаар 150 км, урдаас хойшоо 170 км сунаж 6047,93 км² талбайг эзлэн оршдог. Баруун талаараа БНХАУ-тай 27.47 км, хойд талаараа ОХУ-тай 186 км, болон баруун талаараа Цэнгэл сумтай 271 км, зүүн өмнөд талаараа Сагсай сумтай 176 км, зүүн хойд талаараа Ногооннуур сумтай 29.7 км, зүүн талд Бугат сумтай 48.5 км газраар хиллэнэ. Засаг захиргааны нэгжийн хувьд 11 багт хуваагддаг.

Улаанхус сум нь Баян-Өлгий аймгийн нэг бөгөөд төв нь Билүү юм. 2014 онд хүн ам нь 8 010 орчим байсан. 2021 оны байдлаар 1 929 өрх, 9 173 хүн амтай, хүн амын нягтралаар 1.4 хүн/км² байна. 2020 оны статистик дээр хүн ам 8 756 байсан ба өсөлттэй байгааг харуулж байна.

Мал аж ахуй

Эдийн засгийн гол тулгуур нь мал аж ахуй бөгөөд ДНБ-ний 65%-ийг бүрдүүлдэг. 2021 оны байдлаар нийт малын тоо 221 105 толгой бөгөөд үүнээс тэмээ 737, адуу 10 098, үхэр 19 269, хонь 109 654, ямаа 81 347 байна.

Аялал жуулчлалын боломжууд

Улаанхус сум Алтай Таван Богд байгалийн цогцолборт газар, Цагаан салаагийн хадны сүг зураг, Даянгийн ой зэрэг үзэмжит байгаль орчны онцлогтой. Энэ нь аялал жуулчлал хөгжүүлэх боломжийг нээж өгдөг.

Мэдээлэл, харилцаа холбоо

2007 онд Mobicom, 2010 онд Unitel, Skytel, G-Mobile зэрэг операторууд үүрэн холбоог нэвтрүүлж, Хөх хөтөл, Согоог, Даян багуудад G-Mobile сүлжээ хүртэл ажиллаж байна. 2014 оноос сумын төв болон зарим багуудыг шилэн кабелийн сүлжээнд холбосон.

Нийгмийн дэд бүтэц

2012 онд Японы засгийн газрын санхүүжилтээр Хөх хөтөл багт хүн-эмнэлгийн өргөтгөл хийгдсэнээр иргэд өөрсдийн ойрын төвд илүү сайн эрүүл мэндийн үйлчилгээнд хүрэх боломжтой болсон.

Зам, харилцаа холбоо болон логистик

- Зам засвар, авто замын нөхцөл

2023 онд Улаанхус сумын өвөлжилт хүндэрсэн үед (цасны зузаан 35–50 см, зам хаагдах) нутгийн иргэд, багаас сумын Засаг даргын газраас шатахууны дэмжлэгтэйгээр зам, давааг засаж, машин техникээр зам цэвэрлэх ажлыг зохион байгуулжээ.

- Тээвэр, орон нутгийн холбоо

Улаанхус сум нь аймгийн төв Өлгийтэй 45–46 км-ийн зайд байрладаг.

- Аймгийн түвшний холыг холбосон замын асуудал

Баян-Өлгий аймгийн хэмжээнд авто замын хөгжилд анхаарлаа хандуулж буй бөгөөд Цагааннуурын боомттой холбож, Өлгий хотыг Увс аймгийн Улаангом хоттой авто замаар холбох зэрэг ажлыг төр-хувийн хэвшлийн түншлэлээр шийдвэрлэх саналыг гаргасан байна. холбох зэрэг ажлыг төр-хувийн түншлэлээр шийдвэрлэх саналыг гаргасан байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Тус төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь газрын хэвлий, агаар, ус, хөрс, ургамлан нөмрөг юм.

3.1. Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн талбай болон орчны байдалтай танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

Хүснэгт 67. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт			х		х					
Гадаргын урсцын өөрчлөлт			х		х					
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х		х	х		
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х		х	х		
Геологийн тогтцын өөрчлөлт	х				х		х	х		
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт		х							х	
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										
2. Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	х				х				х	
Бэлчээрийн байдал			х		х					
Эрдэс түүхий эдийн нөөц	х				х				х	
Эрчим хүчний нөөц	х				х				х	
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Газрын доорх усны чанар, хэмжээ			х		х					
Гадаргын усны чанар хэмжээ			х		х					
Агаарын бохирдол			х		х					
Хөрсний бохирдол			х		х					
Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх			х		х					

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
Дуу чимээ, шуугианы нөлөө		х			х					х
4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	х				х				х	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	х				х				х	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх			х		х					
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			х		х					
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх			х		х					
5. Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+				+	
Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх		+			+					+
Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх	+				+				+	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх			х		х					
6. Эдийн засагт үзүүлэх нөлөө										
Татварын орлого өөрчлөгдөх	+				+					+
Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+					+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+			+					+
Ажлын байр нэмэгдэх	+				+					+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+				+					+
7. Бусад нөлөөлөл										
Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах			х		х					
Дүн	14	4	13	0	30	0	3	3	8	7

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

Шууд нөлөөлөл:

- Уурхайн олборлолт үйл ажиллагааны улмаар хөрс хуулах, олборлолт зэргээс хөрсөн бүрхэвч ухагдаж, ургамлан нөмрөг талхалгагдаж урт хугацаанд шууд хүчтэй нөлөөлнө;
- Уурхайн олборлолтын ажлын улмаас геологийн тогтцод, байгалийн үзэсгэлэнт өнгө төрх, өөрчлөгдөх болон ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх зэргээр шууд урт хугацаанд дунд зэрэг нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө;

Шууд бус нөлөөлөл:

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө;
- Ордын олборлолтын үйл ажиллагааны үр дүнд дуу чимээ нь шууд бусаар урт хугацаанд сөргөөр нөлөөлнө;

Богино хугацааны нөлөөлөл:

- Төслийн үйл ажиллагааны явцад дуу чимээ тодорхой хугацаагаар ихэснэ.

Хүчтэй нөлөөлөл:

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хөрс болон ургамлан, геологийн тогтцод, байгалийн үзэсгэлэнт өнгө төрх, өөрчлөгдөх болон

ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх зэргээр хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт орших “Кавернболд” ХХК-ийн Улаанхус нэртэй газар байрлах “Нуурын голын гянтболдын ордыг ил, далд аргаар ашиглах” төслийн ашиглалтын 5 жилийн БОМТ-г БОУАӨЯ-ийн сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ийг баримтлан боловсруулсан болно.

- Монгол улсын “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь заалтын дагуу төсөл хэрэгжүүлэгч жил бүрийн 12 дугаар сард багтаан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагаар батлуулж байх шаардлагатай;
 - Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.
 - Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэлийн томилсон ажлын хэсэг газар дээр нь хянаж үнэлсэн нэгдсэн дүн 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байвал дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Хүснэгт 68. БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал

№	Ажлын нэр	Зардал, мян.төг
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	8,000.0
2	Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	-
3	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө	Гэрээний үнийн дүнгээр
4	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	ҮАЗ
5	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	12,000.0
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,000.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	5,000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	681.2
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Гэрээний үнийн дүнгээр
10	Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	Гэрээний үнийн дүнгээр
Нийт дүн		27,681.2

5.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 69. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
1	Авто тээврийн хэрэгслээс тоосжилт, хорт хий ялгарах	Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоонд жил бүр тогтмол хугацаанд оруулах	Төслийн талбайд	тогтмол	-	-	Дотоод журмаар	2026 он	Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль MNS 4585:2016
2		Гянтболд тээвэрлэлтийн үед асгарах тоосжилт үүсэхээс хамгаалсан хучлагатай байх	Тээвэрлэлтийн бүх машин	Ширхэг	-	-	Дотоод журмаар	2026 он	
Дүн							-		
Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
3	Хөрсний бохирдол	Тээврийн хэрэгслийн болон явган хүний зам, зогсоол байгуулах, тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, хаалт хамгаалалт хийх	Төслийн талбай	удаа	-	-	5,000,000	2026 он	MNS 3297-1991 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарт
4		Уурхайн орчныг тэмдэгжүүлэх, хил хязгаар тогтоох		удаа	400	5	2,000,000	2026 он	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
Дүн							7,000,000		MNS 4597 : 2013 Авто замын тэмдэг. техникийн шаардлага

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
5	Амьтан	Цахилгаан дамжуулах шугамд шувуу үргээгч байрлуулах	Төслийн талбайн цахилгааны шугам болон хаягдлын сан	ширхэг	200.000	5	1,000,000	2026 он	Амьтны тухай хууль
Дүн							1,000,000		
Нийт дүн							8,000,000		

6.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2026 онд уурхайн төлөвлөлтийн ажил хийгдэх тул техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.

7.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Хүснэгт 70. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал,	Нийт зардал,	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Монгол Алтайн нурууны УТХГ-ын хамгаалалтын захиргаатай хамтран биологийн олон янз байдлыг хамгаалах дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх	Сийлхэмийн нурууны БЦГ-ын “А” хэсэг түүний орчны бүсийн Алтайн аргаль хонины тоо толгой, хил орчмын тархац нутаг, өнөөгийн нөөцийг судлах судалгааны ажил хийх	Төсөл хөтөлбөр	Жил бүр	12,000,000.0		Жил бүрийн II-III дугаар улиралд	Байгаль орчны үнэлгээний тухай хууль
	Байгаль цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд уулын тууртан амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээ авах, намар биотехникийн арга хэмжээнд зориулж өвс, давс бэлтгэх	Биотехникийн арга хэмжээ				Жил бүрийн I-III дугаар улиралд	
	Байгаль хамгаалагч, идэвхтэй байгаль хамгаалагч нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх	Төсөл хөтөлбөр				Жил бүрийн IV-дүгээр улиралд	
	Уулын тууртан амьтны тархац нутгийн булаг шандын эхийг задгайлах ажлууд	Төсөл хөтөлбөр				Жил бүрийн III-дугаар улиралд	
Нийт дүн				12,000,000.0			

8.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 71. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Нөлөөллийн бүсэд байгаа айл өрхийн газар эзэмших, ашиглах эрх хөндөгдөх	Уурхайн ашиглалтын талбай болон нөлөөллийн бүсийн айл өрх	Нөлөөллийн бүсийн айл өрх	Гэрээний үнийн дүнгээр	2026 он	
Нийт дүн			-		

Жич: Төслийн талбайд нүүлгэн шилжүүлж нөхөн олговор олгох айл өрхгүй байхгүй болно.

9.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх
- Лицензтэй талбайгаас олборлолтын үед түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.
- Төслөөс шууд өртөж нөлөөлөгдөхөөргүй цэгүүдийг хамгаалах ажиллагаа, соёлын ба үнэт өв дурсгалтай газрыг хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулахдаа төв, орон нутгийн удирдах байгууллага, мэргэжилтнүүд, орон нутгийн олон нийтийн байгууллага, ШУА-ын Археологийн Хүрээлэн зэрэгтэй зөвлөлдөнө. Энэ төлөвлөгөө, хөтөлбөрийг төслийн бүтээн байгуулалт эхлэхээс өмнө төлөвлөж мөрдөнө.

Хүснэгт 72. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй.	Хэрэв төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Төсөл хэрэгжүүлэх нийт талбайн хэмжээнд	Тухайн үед нь шийдэх	Үйл ажиллагааны турш	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/

10.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 73. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар							
Төслийн үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх	Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, хамруулах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		2026 он	MNS 4968:200“ХААЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага” MNS 4995:2000, “ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS 5002:2000, “ХААЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага” MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага” MNS 5010:2001, “ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS 5105:2001, “ХАБ. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS ILO OSH 1:2003, “ХААЭА-н удирдлагын тогтолцооны талаарх удирдамж” Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	
	Ослын үед ажиллах ИТА, ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, сургалт явуулах	Төслийн талбайд	-		2,000.0	2026 он	
	Нийт ажилчдад ХАБЭА шаардлага хангасан өвөл, зуны иж бүрэн хувцас, хэрэгслээр хангах	Нийт ажилчид	-	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		Жилд 1 удаа	
	Нийт ажилчдыг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах.	Нийт ажилчид	-	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		Жилд 1 удаа	
	Болзошгүй осол аюулын үед орон нутгийн эмнэлэг болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар тохиролцож гэрээ байгуулж ажиллах	Төслийн талбайд	Гэрээний үнийн дүнгээр				
Нийт зардал мян. төг					2,000.0		

11.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэнд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй. Хог хаягдлыг энгийн, ахуйн, аюултай гэх мэтээр Монгол улсын Хог хаягдлын тухай хуульд заасан бөгөөд эдгээрийг хэлбэрээр нь хатуу, шингэн, хийн гэж ангилав.

- Энгийн хог хаягдал гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг хэлнэ.
- Ахуйн хог хаягдал гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг хэлнэ.

Энэхүү БОННУ-ний тайлангийн 4.8.2-т хог хаягдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийн авна уу. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг 2017 онд батлагдсан Хог хаягдлын тухай хуулийн үзэл баримтлал, зүйл заалтыг үндэслэн боловсруулав.

Хүснэгт 74. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, ялгах, хог хаягдлыг дахин ашиглах	Хог хаягдал ангилах ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих	Энгийн хог хаягдлаас үүсэх нөлөөллийн бүс	удаа	-	-	5,000.0	2026 он	Хог хаягдлын тухай хууль; БОУАӨЯ-ны сайдын А/433 тушаал “Ариун цэврийн тухай” хууль;
Хог хаягдлаас ялгарах үнэр, амархан муудаж ялзрах бусад хүнсний хаягдал зэргээс халдварт өвчин тархах	Хуванцар сав, шил, лааз, дугуй, модны хаягдал, автомашины сэлбэг, төмрийн хаягдал, цаасны хаягдал гэх мэт дахин ашиглах, дахин боловсруулах боломжтой хаягдлуудыг нэг дор цуглуулж хуримтлуулах, боломжтой бол хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах	Энгийн хог хаягдал	удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр			2026 он	БОУАӨЯ-ны сайдын 2017 оны А/349 тушаал Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл;
	Хөрс шатах тослох материалаар бохирдсон	Төслийн талбай	Иж бүрэн	Үйл ажиллагааны зардал			2026 он	БОУАӨЯ-ны сайдын 2017 оны А/368 тушаал Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал; БОУАӨЯ-ны сайдын 2018 оны А/18 тушаал Аюултай

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах							хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах;
	Хатуу хог хаягдлыг зориулалтын битүүмжилсэн саванд хадгалж, байгаль орчны болон эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагын тогтоосон цэгт зайлуулж байх	Төслийн талбайд	Удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр			2026 он	БОУАӨЯ-ны сайдын 2018 оны А/443 тушаал Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага;
Аюултай хог хаягдал болон шатах тослох материалаар хөрс, газрын доорх ус бохирдож болзошгүй	Хэрэглэсэн батареи, принтерийн хор гэх мэт ахуйн аюултай хог хаягдлыг уурхайн талбайд битүүмжлэл сайтай хадгалах	Аюултай хог хаягдал	Удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр			2026 он	БОУАӨЯ-ны сайдын 2018 оны А/445 тушаал Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар;
	Үйл ажиллагаанаас гарсан ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан, хаягдал тос боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулан зайлуулах	Аюултай хог хаягдал	Удаа				2026 он	БОУАӨЯ-ны сайдын 2018 оны А/21 тушаал; MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
Нийт зардал мян. төг						5,000.0		

12.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 75. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян. төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын чанар						
CO ₂ , NO ₂ , SO ₂ Тоос нийт (PM ₁₀ , PM _{2.5}), Дуу шуугиан хэмжээ	Уурхайн карьер-2 цэг Уурхайн гадаад тээврийн зам дагуу-2 цэг Уурхайн кемп-1 цэг	Жилд 3 удаа	5 цэгт	-	200.0	- MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн шаардлага
Цацрагийн хэмжилт K-40 Ra-226 Th-232 Радийн эквивалень	Уурхайн карьер- 1 цэг Бүтээгдэхүүн буулгах талбай-1 цэг	Жилд 1 удаа	2 цэгт	35.0	/Гэрээний үнийн дүнгээр /	- ЦАН-2015
Хөрс						
Хөрсний агрохимийн үзүүлэлт Хөрсний хүнд металлууд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr гэх мэт)	Хөрсний мониторингийн- 4 цэг Уурхайн карьер-2 цэг Уурхайн гадаад тээврийн зам дагуу-2 цэг Уурхайн кемп-1 цэг	Жилд 3 удаа	9 цэгт	-	421.2	- MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
Усны чанар						
Ерөнхий хими, бактерлоги	Унд ахуйн ус-1 цэгт	Жилд 3 удаа	1 цэгт	-	60.0	- MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Нийт зардал мян. төг					681.2	

13.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 76. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хуваарь					Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2026 он						
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Тохиролцох	Тухайн бүр шийдэх					Үйл ажиллагааны менежер	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Уурхайн дотоод төлөвлөлтөөр		4-р улирал				Үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайлан, төлөвлөгөөг холбогдох газарт хүргүүлэх.	Уурхайн дотоод төлөвлөлтөөр		4-р улирал				БО-ны мэргэжилтэн	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Уурхайн дотоод төлөвлөлтөөр						БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Улаанхус сумын төвд нийт 500 мод тарьж, дуслын усалгааны систем суурилуулна. Мөн энэхүү ажлын хүрээнд жил бүр сумын төвд 100 мод тарьж, агротехникийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	Гэрээний үнийн дүнгээр		4-р улирал				БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
Нийт зардал мян. төг	-	-						

14.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх арга хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
БОУАӨЯ	БОМТ-н жилийн төлөвлөгөө	БОННУ-р тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, зөвлөмж, батлагдсан БОМТ-нд үндэслэн тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах	Жил бүрийн 12-р сард	Төлөвлөгөө батлуулах	БОУАӨЯ
Баян-Өлгий аймгийн БОГ-т	БОМТ-н жилийн тайлан	Төлөвлөгөөний хэрэгжилт, ОХШХ-н хэрэгжилт	Жил бүр 11-р сарын 1-ний дотор	Тайлан хянуулах	Баян-Өлгий аймгийн БОГ-т
БОУАӨЯ-ны сайдын 2019 оны А/618 тоот тушаалын хавсралт 4.3-т заасны дагуу ажлын хэсгийг тухайн аймаг, нийслэлийн ЗД-ын захирамжаар байгуулна.	БОМТ-н жилийн төлөвлөгөө, тайлан	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Жил бүр 11-р сарын 30-ний дотор	Тайлан хянуулах, дүгнүүлэх (хяналтын хуудас авах)	Аймаг, нийслэлийн ЗД-ын захирамж
Багийн ИНХ (нөлөөллийн бүсэд оршин суугч)	Танилцуулга, илтгэл болон мэдээлэл өгч хурлаар хэлэлцүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг БО-ны бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах	Жилд 1 удаа	Инженер техникийн ажилтан	Багийн төв болон төслийн талбайд
Нийт дүн			-		

